

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ДЭД САЙД Д.ЗАГДЖАВЫН ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ
ДЭЭР ХИЙСЭН МЭДЭГДЭЛ

2018 оны 01 дүгээр сарын 15

Улаанбаатар хот

Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе

“Тэвчээрт хязгаар бий” Энэ бол Монголын ард түмний санаа бодлын илэрхийлэл юм.

Би тэдний өмнөөс Монгол Улсын Уул Уурхай Хүнд Үйлдвэрийн Дэд сайдын хувьд “Рио Тинто” компанийг Монголын ард түмний нийгэм, эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулахыг шаардаж байгаа юм.

Рио Тинто түүний охин компани болох Канад Улсын *Turquoise Hill Ltd*/ буюу монголоор бол “Оюу толгой” компани хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн хэд хэдэн үүргээ биелүүлэхгүй манай орны эрх ашгийг хохироосоор өдийг хүрлээ.

- Тэд эхний ээлжинд: зам тээврийн асуудлыг авто болон төмөр замын аль ч хэлбэрээр шийдэх ёстой байсан.

Гэтэл өнөөдөр манай Монголчуудын чадан ядан барьж байгуулсан авто замаар чихэлдэж давуу эрх эдлэн тээвэрлэлт хийж, олон мянган жолооч тээвэрчид зуун зуун километрийн урт дараалалд saatаж, түвэг бэрхшээл үүсгэх нэг нөхцөл болсоор байна.

- Дараагийн дугаарт: Монгол Улсад цахилгаан станц барьж байгуулах ёстой байсан. Үүнийгээ хийж хэрэгжүүлэхгүй гаднаас жил бүр 140-150 сая ам.долларын цахилгаан эрчим хүч импортоор авч ашигласаар байна.

- Цааш нь: Нөгөө зэс хайлуулах үйлдвэр байгуулах яасан??? Алт болон бусад эрдэсийг нь тооцохгүйгээр 3 сая гаруй тонн зэсийн баяжмалыг концентраци хэлбэрээр гаргаад байна.

- Түүнчлэн: Монголын ард түмний баялагыг олборлон борлуулж хангалттай ашиг олж байгаа энэ компани нийгмийн хариуцлагын хүрээнд яагаад санаачлагатай ажиллахгүй байгаа юм.

Зарим нэг хүмүүсийг ажилд авсан, томилсон, төдий хэмжээний ажлын байр бий болгосон жижиг хэмжээний эд материалын болон мөнгөн тэтгэлэг олгосон, Өмнөговь аймгийн хөгжилд зориулж жил бүр 5 сая ам.долларын төсөл санхүүжилтийг өөрсдөө оролцож хэрэгжүүлсэн төдийхнөөс өөр дорвитой ажил зохион байгуулахгүй байна.

Жишээ нь: Оюу толгойн баялагт түшиглэн Өмнөговь аймгийн Ханбогд сумыг өргөжүүлэн хөгжүүлж орчин үеийн Ханбогд хэмээх шинэ хотыг яагаад байгуулж болохгүй байна???. Ингэж жижиг ч болсон жудаг гаргаж баялагын эзэн манай ард түмнийг баярлуулмаар байна.

Гэтэл гадна талд Монгол улс түүний Засгийн газрын нэрийг барьж манай баялагаар том том хэмжээний арилжаа хийж, хөрөнгө босгож, тэрбум тэрбум долларын санхуулжилт олж байгаа хэрнээ, манай улсад оруулахгүй байгаа нь бидний тэвчээр алдрах нэг шалтгаан болоод байгаа юм.

Дээр хэлсэнчлэн 5,4-6 тэрбум ам.долларын хөрөнгө босгоод тэрбум гаруйхныг нь “Оюу толгой” төсөлд оруулж бусдыг нь гадна тараасан.

Үүнийг нь баталж Олон улсын хөрөнгийн биржийн брокерууд Рио Тинтог бүгдээгдэхүүн борлуулалтын орлогоо буцаан өгөх амлалтаа сайн биелүүлсэн гэж дүгнэсэн байгаа юм.

Та бүхэн өөрийнх нь сайтруу ороод [/www.turquoisehill.com/](http://www.turquoisehill.com/) Рио Тинтогийн хувьцаа эзэмшигдээ “Зул сарын баяр эрт ирлээ”, 2015-12-14-ний мэдээллүүдийг тус тус хараарай.

Рио Тинто компани Монголын Оюу толгойг Канадын Оюутолгой компани болгон эзэмшиж байгаагаас гадна, АНУ-ын Бингхам Канионы зэсийн уурхайг мөн эзэмшиж байна.

Чили улсын Эскондидагийн уурхай дэлхийн хамгийн том зэсийн уурхайд тооцогддог. Энэ уурхайн дийлэнхи хувийг АНУ-ын Би-Эйч Пи компани, 30 хувийг Рио Тинто эзэмшдэг.

Индонез улсын Грасбергийн зэс-алтаараа дэлхийд хамгийн томд орох уурхайн 51 хувийг АНУ-ын Фрийпорт МакМоран компани, 40 хувийг Рио Тинто компани 9,3 хувийг Индонезийн засгийн газар тус тус эзэмшиж байна.

Рио Тинто компани нь Индонезид үйл ажиллагаа явуулж байхдаа тухайн улсын ард иргэдийн эрх ашгийг урт удаан хугацаанд мөн л хойш нь тавьж Грасбергийн уурхай дэлхийн хамгийн том орд байж болох ч дэлхийн хэмжээний ашигтай бизнес биш байж магадгүй, Грасбергийн уурхай дэлхийн хэмжээний нөөц гэдэг ойлгомжтой асуудал, гэвч дэлхийн хэмжээний нөөц, дэлхийн хэмжээний бизнес хоёрт маш их ялгаа бий гэх зэрэг мэдэгдлүүд хийж байсан нь Индонезийн ард түмэн, тэдний засгийн газрын дургүйцлийг төрүүлсэн байж болзошгүй байгаа юм.

Индонез Улс уурхайг хэд хэдэн удаа зогсоож шинэ өмчлөлийн дүрэм гаргаж гэрээндээ өөрчлөлт оруулсны дунд 25 жилийн туршид олон тэрбум долларын хөрөнгө оруулалт хийсэн Рио Тинтог гаргаж, 40 хувийн хувьцааг худалдаж авах, шинэ өмчлөлийн дүрмийн дагуу 2017оны 8-р сард Грасбергийн

урхай дахь АНУ-ын Фрийпортийн эзэмшийн 51 хувийг ПТ Иналум төрийн өмчт компаниараа дамжуулан Засгийн Газрынхаа мэдэлд авч, 5 жилийн дотор зэс хайлуулах үйлдвэр баруулах ажлыг 2017оны 7-р сард тус тус тохироод байна.

Энэ талаар Индонез Улсын Эрчим хүч Ашигт малтмалын сайт Игнасиус Жонан: 2018 онд Индонез улс Риогийн Грасбергийн хувьцааг худалдаж авах гэж байгаа тухайгаа Ройтерс агентлагт мэдээлсэн.

Тэрбээр хувьцааг 6-7 тэрбум ам.долларын өртөгтэй гэж үздэг бөгөөд энэ тухайгаа зөв тооцоолсон гэж итгэж байна хэмээсэн. Грасберг дахь Риогийн хөрөнгө оруулалт 2 тэрбум ам.долларт хүрч цэвэр ашгийн хэмжээ нь 1,7 тэрбум ам.доллар байгааг сүүлийн 20 жилийн санхүүгийн тайлангаас харж болно.

Индонезийн Папуа дахь Грасбергийн уурхай 2017 онд гэхэд л 450000тн зэс 1,6 сая унц алт олборлоод байна.

Дэлхийн зах зээл дээр Английн Rio Tinto компани 60 орчим тэрбум ам.доллар, АНУ-ын Apple компани 700 гаруй тэрбум ам.долларын тус тусын ханштай байна.

Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 10 тэрбум ам.доллар, тэгэхээр Rio Tinto компани манай эдийн засгаас 6 дахин том, Apple компаниас 12 дахин жижиг харагдаж байгаа.

Дээрхи компаниудаас бидний эх орон Монгол Улс, тусгаар тогтолц, ард түмэнтэйгээ, газар нутаг, мал сүрэг, байгалийн баялагтайгаа хэдэн 10 дахин том, дээрээс нь ОХУ, БНХАУ гэсэн хүчирхэг 2 том хөрштэйгээ нэмбэл олон улсын банк санхүүгийн байгууллагууд ч жижигдэнэ шүү дээ.

Бидний сайн мэдэх Дубайн гэрээний дараа 2015 оны 12-р сарын 16-д Rio Tinto компаний Зэс, нүүрсний группын /риогийн охин компани/ Ерөнхий захирал Жан Себастьян Жак хэлсэн үгийнхээ төгсгөлд:

“Бидний хамтдаа бүтээн байгуулж байгаа зүйл урт хугацааны, тогтвортой бизнес гэдгийг бид санах хэрэгтэй. Бид Монгол Улс, монголчуудад дараа дараагийн олон үед нь хувь нэмэр оруулах бүтээн байгуулалт хийхийг хүсэж байна.” гэж ярьж байсан нь манайд ашиггүй гэрээ болж гадныхан хожиж дээрх нехэр ч 6 сарын дараа 2016 оны 7-р сарын 02-ний өдөр албан тушаал ахиж толгой компани буюу Rio Tinto компанийхаа Ерөнхий захирал болсон.

2012 оноос унаж эхэлсэн зэсийн үнийн уналт 2016 оны эхээр 4400 ам.доллар байсан бол одоо 7200 ам.доллар болж 2018 ондоо 8000 ам.доллар ч хүрэх төлөвтэй байна.

Үүнээс манай улсад юу олдож байна. Улс орны өрийн данс нэмэгдсээр, зээл, зээлийн хүү, хүүгийн хүү төлөх хугацаанд шахагдсаар, иргэдийн амьдрал ч

төдийлөн сайжирч орлого нэмэгддэггүй, цалин тэтгэвэр тэтгэмж нэмэхийг шаардсаар, ирээдүй хойч үедээ ч юу үлдээх нь тодорхойгүй, нийгмийн халамж, хамгаалалын тулгамдсан асуудлууд, нийслэл хотын төвлөрөл бөөгнөрөл, хуучирсан дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний өргөтгөл шинэчлэл, авто замын хөдөлгөөний түгжрэл, агаар орчны бохирдол, ажилгүйдэл ядуурал гээд буман асуудал шийдлээ хулээсээр...

Нөхцөл байдал ийм байхад бид эвлэрээд яваад байх уу???, Харин

Индонез зэрэг зарим улсын туршлагыг судлан, тэдний алдааг давтахгүйгээр Оюу толгойн ордыг ашиглах гэрээ, эрх зүйн орчинг боловсронгуй болгон эдийн засгийн менежментийг сайжруулан, Монгол Улсын “Оюу толгой” компанийн менежмент, мөнгө, санхүүгийн гүйцэтгэх удирдлагыг Канад Улсаас өөрийн улсад оруулж ирэн, Монгол Улсын хуулийн этгээдээр бүртгэн, манай улсад үйл ажиллагаа явуулах нөхцлийг нь бүрдүүлж, өртөг зардлыг нь хямдруулан, үр өгөөжийг нь нэмэгдүүлэн, ирээдүйд чиглэсэн бодлогоор, эрдэс баялагаа зөв зохистой ашиглан улс орныхоо эдийн засгийг хүчирхэгжүүлж хүн ардынхаа амьдрал ахуйг тэтгэх шаардлага зүй ёсоор тулгараад байгааг албан ёсоор мэдэгдэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.